

БАТЛАВ
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЭРДЭНЭБИЛЭГ

2018 оны сарынөдөр

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

2018 оны 08-р сарын 30 өдөр

Улаанбаатар хот

1. Зорилго

Нийтлэг үйлчилгээний газрын зоогийн газар, цайны газруудын эрүүл ахуй, хоол үйлдвэрлэл, түүний хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэвийн ажиллагааг хангах, зөрчил дутагдал, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2. Хамрах хүрээ

Нийслэлийн засаг захиргааны 1, 2, 5-р байруудад байрлах зоогийн газар, цайны газрууд

3. Хугацаа

Ажлын хэсэг хяналт-шинжилгээг 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 17-ны өдрийг дуустал

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Шинэчимэг

Гишүүд: Үйлчилгээний албаны дарга Л.Уранхайч
Цахилгааны инженер З.Эрдэнэбаяр
Их эмч Н.Энхзаяа

Нарийн бичиг: Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний
ажилтан Т.Итгэл

5. Хяналт-шинжилгээ хийх чиглэл

5.1 Хяналтын хуудасны асуултуудын хүрээнд хяналт-шинжилгээ хийх;

5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, түүний мөрдөлтөнд хяналт тавих;

5.3 Шаардлагатай гэж үзсэн бусад ажил;

6. Бусад

6.1 Ажлын хэсэг хяналт-шинжилгээ хийхдээ холбогдох баримт бичгийг судлах, асуулга явуулах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

6.2 Хяналтын хуудас нь энэхүү удирдамжийн салшгүй хэсэг байна.

6.3 Ажлын хэсгийн гишүүд хариуцсан чиглэл тус бүрээр хяналт-шинжилгээ хийж, аливаа дутагдал, түүний шалтгаан нөхцөл, арилгах арга замын тухай саналыг боловсруулж, газрын даргад танилцуулна.

---o0o---

**ЗООГИЙН ГАЗАР, ЦАЙНЫ ГАЗРУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ХЭСГИЙН**

ИЛТГЭХ ХУУДАС

2018 оны 09 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаад хяналт шинжилгээ хийх ажлын хэсэгт Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Шинэчимэг, үйлчилгээний албаны дарга Л.Уранхайч, цахилгааны инженер З.Эрдэнэбаяр, их эмч Н.Энхзаяа, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Т.Итгэл нар ажилласан ба 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрүүдэд хяналт шинжилгээг хийлээ.

Ажлын хэсэг тус газрын даргын 2018 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Бодлогын болон захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт, Нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгон ажиллалаа.

Хангардийн зоогийн газар, Тамгын цайны газар, Улаанбаатар чуулгын цайны газруудад тус тус газар дээр нь очиж ажиллан, хяналтын хуудасны нийт 6 үндсэн хэсгийн 37 асуултуудын хүрээнд оноогоор дүгнэсэн.

Оноог нэгтгэхдээ ажлын хэсгийн гишүүдийн онооны дундажыг онооны хязгаарт харьцуулж, гүйцэтгэлийн хувийг гаргасан. Оноогоор дүгнэсэн байдлыг нэгтгэж хүснэгтээр харуулав.

Зоогийн газар, цайны газар	Хангарди ордны зоогийн газар		Тамгын цайны газар		Улаанбаатар чуулгын цайны газар	
	Оноо	Гүйцэтг элийн хувь	Оноо	Гүйцэтгэ лийн хувь	Оноо	Гүйцэтг элийн хувь
Үзүүлэлтийн үндсэн хэсэг						
I хэсэг. Орчин, барилга байгууламж	18	73%	17	75%	17	75%
II хэсэг. Ажилтан, албан хаагчийн эрүүл ахуй	4	87%	3	90%	10	67%
III хэсэг. Угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэл, халдвараас сэргийлэх	7	91%	10	88%	13	84%
IV хэсэг. Түүхий						

эдийн хүлээн авах, хадгалах	0	100%	0	100%	1	89%
V хэсэг. Технологи, тоног төхөөрөмжинд тавигдах шаардлага	2	93%	4	87%	6	80%
VI хэсэг. Бүртгэл, хөтлөлт	9	91%	5	95%	25	75%
Нийт үнэлгээ	40	87%	39	88%	72	77%

Дээрх хүснэгтээс хархад Хангарди ордны зоогийн газрын үйл ажиллагаа 87% буюу хангалттай, Тамгын цайны газрын үйл ажиллагаа 88% буюу хангалттай, Улаанбаатар чуулгын цайны газар 77% буюу ажил сайжруулах шаардлагатай гэж дүгнэгдсэн байна.

Онооны тайлбар:

Үзүүлэлтийн үндсэн хэсэг	Хангалтгүй оноо /0% гүйцэтгэлтэй/	Хангалттай оноо /100% гүйцэтгэлтэй/
I хэсэг. Орчин, барилга байгууламж	67	0
II хэсэг. Ажилтан, албан хаагчийн эрүүл ахуй	30	0
III хэсэг. Угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэл, халдвараас сэргийлэх	82	0
IV хэсэг. Түүхий эдийн хүлээн авах, хадгалах	6	0
V хэсэг. Технологи, тоног төхөөрөмжинд тавигдах шаардлага	30	0
VI хэсэг. Бүртгэл, хөтлөлт	100	0

Хяналт шинжилгээ хийх явцад:

- Зоогийн газар, цайны газруудын сантехникийн шугам хоолойд засвар үйлчилгээ хийх, ил байгаа бохирын шугам, хоолойг битүүмжлэх;
- Хангарди зоогийн газар болон Тамгын цайны газрын гэрлийн шилийг бүрхүүлтэй болгох;
- Тамгын цайны газрын цахилгааны шит, кабелийн аюулгүй ажиллагааг хангах;
- Улаанбаатар чуулгын цайны газарт ундны усны шинжилгээ хийлгэх, цэвэрлэгээ ариутгалын хуваарь гаргаж батлуулах, гар угаах санамжийг солих, анхны тусламж үзүүлэх эмийн сантай болох;
- Дээжний савыг хаягжуулах;
- Мах махан бүтээгдэхүүний ангилал, хаягжуулалтыг хийх;
- Заалны гэрлийн бүрэн бүтэн байдлыг хангах;

- Бүртгэлүүдийг тогтмол хөтлөх;
- Ариутгалын бодисын хэрэглээг сайжруулах, найруулсан бодисыг хаягжуулах зэрэг шаардлагатай зарим дутагдлыг засах хугацаатай үүргийг хариуцсан албан хаагчдад өгч зарим зөрчлийг газар дээр нь арилгуулан ажиллаа.

Цаашид:

- Сантехникийн шугам хоолойн хэвийн ажиллагааг хангах,
- Хоол үйлдвэрлэлийн болон заалны өрөөнд гэрэлтүүлгийн шаардлагыг хангах,
- Мах, махан бүтээгдэхүүний ангилал, хаягжуулалтыг хийх,
- Цэвэрлэгээний бодисын заавар, хаягжуулалт, хадгалалтадыг шаардлагын дагуу хангах,
- Шаардлагатай бүртгэл, түүний хөтлөлтийг тогтмолжуулах зэрэг арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж, 7 хоногийн хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА

Л.УРАНХАЙЧ

ИХ ЭМЧ

Н.ЭНХЗАЯА

ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР

З.ЭРДЭНЭБАЯР

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ